

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2026 ОНЫ I УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2026.03.30

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
2	3	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20	10.2. Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /10.1.7.хүнсний түүхийг эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/;	<ul style="list-style-type: none"> ЭМС-ын 2017 оны 145 тоот тушаалаар батлагдсан “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах” журмын дагуу 2026 оны I улиралд ЭХСТ-ийн 22 ажилтан /100%/ БГД-ийн Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан. Бүх ажилчид 100% 5 төрлийн эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан. /Сүрьеэ, арьсны халдварт өвчнүүд, нян тээгч, хамар залгиурын арчдас, цагаан хорхой/ Эрүүл мэндийн шинжилгээ өөрчлөлттэй гарсан тохиолдол байхгүй. 	100%		
3	4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар	11.2.. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх	<ul style="list-style-type: none"> Тус төв 5 жолоочтой. Жолооч нарыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. Эрүүл мэндийн шинжилгээ өөрчлөлттэй гарсан тохиолдол байхгүй. Төвийн хэмжээнд 10 автомашинтай. 	100%		

		2015.09.01	эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	<ul style="list-style-type: none"> Автомашин бүрт эмийн сангийн иж бүрдэл, анхны тусламжийн хайрцагтай. 			
5	9	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	15.1.1. Энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан нэг цэгийн үйлчилгээ, энэ хуулийн 38.1.2-т заасан сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх; (15.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	<ul style="list-style-type: none"> 2026 оны 1 дүгээр улиралд сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 192 хүүхэд, 1 ажилтан, 8 ажилтны хүүхэд, 43 насанд хүрэгчид, 189 асран хамгаалагч нийт 433 удаа анхан шатны болон давтан зөвлөгөө өгөв. 2026 оны I улиралд нийт 46 үйлчлүүлэгч, 46 асран хамгаалагчид 101 удаагийн уулзалтаар нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлсэн. Тулгамдаж буй асуудлын хувьд: <ul style="list-style-type: none"> Бие махбодын хүчирхийлэлд өртсөн 3 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 9 Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 6 Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн Насанд хүрээгүй жирэмсэн 18, үүнээс хүчирхийллийн улмаас жирэмсэлж үр хөндүүлсэн 7 үйлчлүүлэгч, төрсөн 4, Амиа хорлох оролдлого хийсэн 8 Архины хамаарал 1 Сэтгэл гутрал, түгшилт 3 Мансууруулах бодис хэрэглэсэн 1 Нийгмийн буюу сургууль завсардалт, харилцааны асуудалтай 5 	100%		

				- Эрүүл мэндийн асуудалтай 10 байсан. -			
6	11	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12	14.2.2. Эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах;	<ul style="list-style-type: none"> Нярайн нэгдсэн тасгаас Хөхний сүүгээр дагнан хооллох 10 алхамын үндэсний сургагч 3 багш бэлтгэгдэж тасаг нэгждээ сургалтыг хийж байна. Бүх нярайг төрсний дараа НЭҮНШТ-ийг үзүүлж анхны амлуулалтыг хийж, үргэлжлүүлэн хөхөөр хооллолтыг дэмжиж эхэд зөвлөн зааж сургаж, эмнэлгээс гарахад 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллолтыг зөвлөж, ач холбогдлыг ойлгуулан гаргадаг. 	100%		
	12		15.3. Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	<ul style="list-style-type: none"> Хөхний сүүний банк байхгүй. 			
8	15	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ЭХЭМҮТ-ийн Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт, 22 ажил бүхий төлөвлөгөө боловсруулан ерөнхий захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 100% 	100%	ХНА	
11	25	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019-05-30 Дугаар 2019.05.30	10.4.4.. Тусгай хоолны дэглэмтэй хүүхдэд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоолны жишиг цэс, зөвлөмж гаргах; (10.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	<ul style="list-style-type: none"> Эмчилгээний хоол судлалын тасаг нь шинээр 20 технологийн карт батлуулж, батлагдсан картын дагуу Эмчилгээний хоолыг өвчний ангилал тус бүрээр нь илчлэг шимт бодисын хэмжээг төлөвлөж бүрдэл хоолны цэс гарган Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, Хангамж үйлчилгээ, инженер технологийн албаны даргаар улирал бүр 50 нийт хоолны цэс батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. 	100%		

	26		10.4.5.. Энэ хуулийн 10.4.1-д заасан судалгаанд үндэслэн хүүхдийн зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах; (10.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	<ul style="list-style-type: none"> Эмчилгээний тусгай хоол шаардлагатай ХБЭЭСТ, ХЭЭТ, МЭСТ, ЭБЭЭ-ийн ЭЭТ, ЕМЗТ-ийн 25 өвчтөнд тухай бүрт цэс зохиож тохирсон хоолоор үйлчилсэн. Өвчтөнүүдийн хоолны илчлэг, шимт бодисын үнэлгээг биеийн жин, нас, хүйс биеийн байдал болон дагалдах өвчин, шинжилгээнүүдэд үндэслэн бүрдэл хоолны цэс зохиож амаар болон гуурсаар хооллохоор тохируулан заагдсан цаг бүрд нь өгч хэвшсэн нь эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлсөн. 	100%		
15	48	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	<ul style="list-style-type: none"> Тус төвийн цахим хуудсанд www.ehemut.mn/ ЭХЭМҮТ-ийн алсын хараа, зорилго, зорилт, бүтэц, зохион байгуулалт, зохион байгуулсан арга хэмжээг www.ehemut.mn хаягт байршуулсан. 	100%		
	49		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	<ul style="list-style-type: none"> Тус төвийн цахим хуудсанд www.ehemut.mn/ ЭХЭМҮТ-ийн алсын хараа, зорилго, зорилт, бүтэц, зохион байгуулалт, байршилын болон холбоо барих хаяг, утас, цахим шуудангийн мэдээлэл байршуулагдсан. Тус хуудасны ИЛ ТОД БАЙДАЛ цэсэнд хүний нөөцийн болон санхүүгийн мэдээллүүд байршуулагдсан байгаа. www.ehemut.mn ба “Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв” page-д /facebook/ тус төвийн хэмжээнд болсон үйл ажиллагаа, арга хэмжээний талаарх мэдээлэл байнга тавигдаж байна. 	100%		
	50		8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл	<ul style="list-style-type: none"> www.shilendans.gov.mn, www.ehemut.mn –д байршуулсан. 	100%		

		ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;				
51		8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	<ul style="list-style-type: none"> Хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 	95%		
52		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	<ul style="list-style-type: none"> www.ehemut.mn цахимд байршуулсан. 	100%		
53		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<ul style="list-style-type: none"> www.ehemut.mn цахимд байршуулсан. 	100%		
54		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	<ul style="list-style-type: none"> www.ehemut.mn цахимд байршуулсан. 	100%		
55		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<ul style="list-style-type: none"> 2026 оны 1-р улиралд бичгээр нийт 45 гомдол, хүсэлтийг цаг тухайд нь хүлээн авч, ЭМТҮЧАБА-ны дарга, эмчилгээ эрхэлсэн дэд захирал, тусламж үйлчилгээ хариуцсан чанарын менежерүүдэд танилцуулж холбогдох алба нэгжүүд хуваарилан, судлуулж үйлчлүүлэгч болон түүний ар гэр, асран хамгаалагч нартай холбогдон цаг хугацаанд нь шийдвэрлэн ажиллаа. Үүнд. Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-2 буюу 4.4% Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой-0 Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой-37- буюу 	100%		

			83.3% • Бусад-5- буюу 12.3%			
56		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" ЭМС-ын А/611 тоот тушаалын дагуу анхан шатны маягтуудыг захиалан төвийн бүх тасаг нэгжүүдийг анхан шатны маягтаар хангаж, маягтын хөтлөлтөнд хяналтыг тогтмол хийн гарсан зөрчлийг тухай бүр засуулан ажиллаж байна. • "Цахим эрүүл мэнд" төслийг хэрэгжүүлэх үүднээс өглөө бүр тасгуудын орны хөдөлгөөний мэдээг авч, гарсан өвчний түүхийг ehealth програмд шалган, хаагдаагүй тохиолдлыг эмч нарт буцааснаар програмын алдааг арилгаж ажилласан. • ЭХЭМҮТ-ийн эрүүл мэндийн үзүүлэлтийн I улирлын мэдээг төвийн цахим хуудсанд байршуулсан. 	100%		
58		8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> • Сул орон тооны зарыг ЭМХТ ба ЭХЭМҮТ-ийн веб хуудас, zangia.mn зарын сайтаар 7-14 хоногийн давтамжтайгаар зарлаж 2026 онд 28 ажилтанг шинээр ажилд авсан. • Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн сар бүрийн 8-ны дотор тухайн сарын хүний нөөцийн орон тоо, гүйцэтгэлийн мэдээг 2026 онд www.shilendans.gov.mn 3 удаа байршуулсан. 	100%		
59		8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	<ul style="list-style-type: none"> • ЭХЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 сарын 10-ны өдрийн А/142 	100%		

			дугаар тушаалаар “ЭХЭМҮТ-д эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан сонгон шалгаруулж авах журам”-ыг шинэчлэн батлуулсан.			
60		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	<ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлэн ажиллаж байна. Ёс зүйн салбар хороо болон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албатай бөгөөд тохиолдол бүрт дүгнэлт хийж хуралддаг. 	100%		
61		8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	<ul style="list-style-type: none"> Ханган ажиллаж байна. 	100%		
62		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<ul style="list-style-type: none"> www.ehemut.mn хаягт хүний нөөцийн сул орон тооны зар болон хүний нөөцийн сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг байршуулж байна. 	100%		
63		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	<ul style="list-style-type: none"> Төвийн бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлон, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгож байна. 	100%		
64		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	<ul style="list-style-type: none"> https://ehemut.mn/ 3 мэдээлэл оруулсан. 	100%		
65		8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	<ul style="list-style-type: none"> https://ehemut.mn/ 2 мэдээлэл оруулсан. 	100%		
66		8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	<ul style="list-style-type: none"> https://ehemut.mn/ 1 мэдээлэл оруулсан. 			
67		8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	<ul style="list-style-type: none"> https://ehemut.mn/ 1 мэдээлэл оруулсан. 	100%		
68		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	<ul style="list-style-type: none"> https://ehemut.mn/ 1 мэдээлэл оруулсан. 	100%		
69		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил,	<ul style="list-style-type: none"> https://gap.mof.gov.mn/ Шилэн дэнсанд хуулийн хугацаанд нь 1 удаагийн мэдээлэл оруулсан 	100%		

		үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;				
70		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	<ul style="list-style-type: none"> • https://gap.mof.gov.mn/ Шилэн дэнсанд хуулийн хугацаанд нь 1 удаагийн мэдээлэл оруулсан 	100%		
71		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	<ul style="list-style-type: none"> • https://gap.mof.gov.mn/ Шилэн дэнсанд хуулийн хугацаанд нь 1 удаагийн мэдээлэл мэдээлэл оруулсан. 	100%		
72		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> • Хугацаа болоогүй 			
73		8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	<ul style="list-style-type: none"> • https://gap.mof.gov.mn/ болон https://www.tender.gov.mn/ мэдээллийг оруулсан. 	100%		
74		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	<ul style="list-style-type: none"> • https://gap.mof.gov.mn/ болон https://www.tender.gov.mn/ мэдээллийг оруулсан. 	100%		
75		8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга	<ul style="list-style-type: none"> • Хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 	100%		

		зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;				
76		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	<ul style="list-style-type: none"> • Монгол улсад сэргийлэх боломжтой эхийн болон перинаталь эндэгдлийг тэглэх үйл ажиллагааг эрчимжүүлэх • Монголын нүд судлалын орчин үеийн шилдэг загвар Хүүхдийн хараа хамгаалах Дутуу нярайн ретинопати, хүүхдийн нүдний тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах ба технологийг дутуу нярайн ретинопати скрининг үзлэгт нэгтгэх төсөл • Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах • Нярайн бодисын солилцооны эмгэгийн оношилгоо скринингийн чадавхийг би болгох 	88,8%		
78		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	<ul style="list-style-type: none"> • https://gap.mof.gov.mn/ болон https://www.tender.gov.mn/ мэдээллийг оруулсан. 	100%		
79		8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> • Ил тод байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. (Касс хажууд мэдээлэл байршуулсан) 	100%		
84		8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> • ЭХЭМҮТ 81082 мкв эзэмшил газартай. 	100%		
89		8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	<ul style="list-style-type: none"> • 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЭХЭМҮТ-ийн 6-4 блок (мэс заслын 5 тасаг)-ын барилгын их засвар хийгдэж, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр улсын 	100%		

				комисс хүлээн авч тасаг нэгжүүд нүүж орсон.			
УИХ-ЫН ТОГТООЛ							
18	99	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	<ul style="list-style-type: none"> Сувилахуйн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж буй 38 сувилагч, эх баригч болон Дорнод аймгийн БОЭТ-ийн Өсвөр үеийн эмчид “Хүүхэд хамгаалалд эмнэлгийн мэргэжилтний үүрэг”, “Хохирогч хүүхэд, гэр бүлд тулгамддаг нийгэм, сэтгэл зүйн асуудлууд”, “Зөвлөгөө өгөх ур чадвар” сэдвээр сургалт зохион байгуулсан. 	100%		
	100	Дугаар 2019 №62	1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;	<ul style="list-style-type: none"> Нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэн мэдээллийг www.ehemut.mn гадаад цахим хуудас, ЭХЭМҮТ пейж хуудас, мэдээллийн самбараар дамжуулан хүргэж байна. Төрөх тасаг иж бүрэн барилгын их засвар хийгдэж, 1 өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй эхэд тусламж үйлчилгээ үзүүлэхээр тоноглогсон. НҮЗП, Төрөх тасгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн ханын бариулаар тоноглогдсон. 	100%		
	101		1.4/г/. эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцүүлэх.	<ul style="list-style-type: none"> ХБХ иргэдийн хуулийн хүрээнд ЭХЭМҮТ-ийн мэдрэлийн эмгэг судлалын тасаг нь нийт хянагдаж байгаа. ХБХ-ийн ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор Хүүхдийн эмнэлгийн бүх тасаг болон коридорт хана дагасан бариул, налуу замыг байршуулсан. Мэдрэлийн эмгэг судлалын тасагт 	100%		

				<p>ХБХ хүүхдийн өрөө, ханын бариул, өрөө болгонд зориулалтын хашлагатай ортой болсон.</p> <ul style="list-style-type: none"> ХБХ хүүхдүүдийг цаг алдалгүй хүссэн цагт очер дараалалгүй үзэх болсон. 			
21	110	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39	1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;	<ul style="list-style-type: none"> Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажлаж байна. Аудитын зөвлөмжийн дагуу ажиллан тайлан мэдээгээ өгсөн. 	100%		
	112		1.6/. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг хагас бие даасан удирдлагын тогтолцоонд шилжүүлж байгаатай холбогдуулан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчнийг чадавхжуулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардагдах багаж, тоног төхөөрөмжийг худалдан авах зардлыг 2021 онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс санхүүжүүлэх.	<ul style="list-style-type: none"> Тогтоолын 1-д заасан арга хэмжээтэй уялдуулан өр, авлага үүсгэхгүйгээр ажилласан. 	100%		
22	115	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12	ЭМЯ хуулийн төсөл 2021. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	<ul style="list-style-type: none"> Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийн хэлэлцүүлгийг төвийн хэмжээнд зохион байгуулан хуульд оруулах саналаа хуулийн төслийн багт явуулсан. 	100%		
	116		ЭМЯ хуулийн төсөл 2022. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай Цусны донорын тухай Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<ul style="list-style-type: none"> ЭХЭМҮТ-ийн хяналтанд элэгний цирроз өвчнөөр хяналтанд байдаг, элэг шилжүүлэн суулгах шаардлагатай жагсаалтад орсон 14 хүүхэд хяналтанд байна. Монгол Улсад анх 2014 оноос хүүхдэд амьд донороос элэг 	100%		

				шилжүүлэн суулгах эмчилгээг ЭХЭМҮТ, УНТЭ хамтран хийж эхэлсэн.			
25	136	Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2022-01-18 Дугаар 2022 №08	1.6/. Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;	<ul style="list-style-type: none"> • Донорын тухай хуулийн хэлэлцүүлэгт саналаа өгсөн. 	100%		
26	138	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-07-06 Дугаар 2022 №49	6.б/. нийгмийн сүлжээний хяналтгүй хэрэглээнээс шалтгаалан цахим гадуурхалтад өртөх, хүүхэд дэлгэцийн хамааралтай болох, цахим гэмт хэргийн хохирогч болох, нас, сэтгэхүйн онцлогт үл тохирох, зүй бус агуулгатай контент үзэх, зан суртахуунд нь сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:)	<ul style="list-style-type: none"> • ТСА-нь 2020 оноос улсын хэмжээнд өсвөр үеийн клиник, төв, кабинетаар тусламж үйлчилж буй нийт 28 ЭМБ-аас өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар хандсан талаарх тоон мэдээлэл цуглуулж эхэлсэн. 	100%		